



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ СУРГУУЛИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Ж.Энхтуяа
Утас: 260512 Цахим хаяг: enkhtyuaj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мишээл-Од Аудит ХХК
Захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗГ	Засгийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

2022.02.23 № 07/244
танай _____ -ны № _____ -г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	154,761,394.28	48,244,683.80
33	АВЛАГА	562,526.30	397,705.69
33500	Бусад авлага	562,526.30	397,705.69
33510	Байгууллагаас авах авлага	562,526.30	397,705.69
35	БАРАА МАТЕРИАЛ	154,198,867.98	47,846,978.11
35400	Хангамжийн материал	154,198,867.98	47,846,978.11
35410	Бичиг хэргийн материал	2,028,892.00	3,389,637.00
35420	Аж ахуйн материал	139,981,685.98	27,273,961.11
35440	Түлш, шатах тослох материал	1,263,500.00	1,901,910.00
35460	Хүнсний материал	1,144,750.00	0
35470	Бусад хангамжийн материал	9,780,040.00	15,281,470.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,957,491,959.83	3,890,871,147.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,957,491,959.83	3,890,871,147.74
39200	Биет хөрөнгө	3,956,433,686.90	3,890,097,814.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,456,901,301.72	3,456,901,301.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(191,707,450.58)	(263,477,232.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,458,333.00	49,228,166.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(98,458,333.00)	(1,367,449.07)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	272,979,199.44	243,354,550.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(155,156,435.42)	(144,134,181.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	223,959,183.90	189,283,304.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(138,705,189.96)	(74,317,953.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	653,998,698.28	653,998,698.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(179,771,060.48)	(241,410,339.92)
39217	Ном	13,935,440.00	22,038,950.00
39300	Биет бус хөрөнгө	1,058,272.93	773,333.33
39301	Програм хангамж	6,627,546.00	6,056,980.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,569,273.07)	(5,283,646.67)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,112,253,354.11	3,939,115,831.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	33,360.45
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	33,360.45
41300	Өглөг	0	33,360.45
41360	Бусад өглөг	0	33,360.45
41310	Ажилчидтай холбоотой өглөг	0	33,360.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,112,253,354.11	3,939,082,471.09
51	Засгийн газрын хувь оролцоо	4,112,253,354.11	3,939,082,471.09
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,942,620.50	265,942,620.50
51200	Хуримтлагдсан үр дүн	3,846,310,733.61	3,673,139,850.59
51210	Өмнөх үеийн үр дүн	3,873,970,207.43	3,846,310,733.61
51220	Тайлант үеийн үр дүн	(27,659,473.82)	(173,170,883.02)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,112,253,354.11	3,939,115,831.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,353,057,483.00	1,744,949,007.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,305,050.00	119,728,997.50
120	Нийтлэг татварын бус орлого	77,305,050.00	114,728,997.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	77,305,050.00	109,217,567.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	23,930,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	77,305,050.00	85,287,567.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		5,511,430.00
122	Тусламжийн орлого		5,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/		5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,275,752,433.00	1,625,220,010.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,173,841,400.00	1,588,560,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,173,841,400.00	1,588,560,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,911,033.00	36,659,410.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	101,911,033.00	36,659,410.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,374,321,016.82	1,904,979,067.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,374,321,016.82	1,904,979,067.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,361,806,121.31	1,692,871,937.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	885,399,672.05	1,026,503,216.8
210101	Үндсэн цалин	885,399,672.05	613,993,499.06
210102	Нэмэгдэл	0	302,656,108.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	53,680,173.31
210104	Урамшуулал	0	56,173,436.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,290,613.88	133,262,143.69
210201	Тэтгэврийн даатгал	78,058,156.63	93,936,170.48
210202	Тэтгэмжийн даатгал	9,183,312.31	10,431,646.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,145,050.85	8,234,275.52
210204	Ажилгүйдлийн даатгал	1,609,535.01	1,855,799.27
210205	Эрүүл мэндийн даатгал	16,294,559.08	18,804,251.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,646,008.64	36,659,409.00
210301	Гэрэл, цахилгаан	15,577,807.47	10,523,763.30
210302	Түлш, халаалт	17,130,706.58	18,294,328.70
210303	Цэвэр, бохир ус	5,937,494.59	7,841,317.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,423,190.49	86,362,785.32
210401	Бичиг хэрэг	2,708,850.00	9,651,927.00
210402	Тээвэр, шатахуун	4,052,705.00	3,611,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,017,435.99	13,859,063.48
210404	Ном, хэвлэл	146,000.00	456,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,448,860.00	7,948,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,049,339.50	50,836,294.84
2105	Нормативт зардал	0	3,027,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	3,027,500.00

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	887,150.00	4,547,866.78
210601	Багаж, техник, хэрэгсэл	887,150.00	4,547,866.78
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,386,756.18	64,604,462.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,572,726.18	62,848,932.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	186,030.00	186,030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,000.00	69,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,772,730.07	337,904,553.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,568,801.50	129,205,812.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	177,203,928.57	208,698,740.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,514,895.51	212,107,130.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,000,000.00	58,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		42,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	16,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,514,895.51	154,107,130.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,404,224.15	154,107,129.01
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	110,671.36	1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(21,263,533.82)	(160,030,059.76)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,395,940.00	13,140,823.26
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	6,395,940.00	13,140,823.26
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(27,659,473.82)	(173,170,883.02)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,942,620.50		3,873,970,207.43	4,139,912,827.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,942,620.50		3,873,970,207.43	4,139,912,827.93
Тайлант үеийн үр дүн			(27,659,473.82)	(27,659,473.82)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,942,620.50		3,846,310,733.61	4,112,253,354.11
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	265,942,620.50		3,846,310,733.61	4,112,253,354.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,942,620.50		3,846,310,733.61	4,112,253,354.11
Тайлант үеийн үр дүн			(173,170,883.03)	(173,170,883.03)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	265,942,620.50		3,673,139,850.59	3,939,082,471.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,275,752,433.00	1,649,150,010.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		23,930,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		23,930,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		23,930,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		23,930,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,275,752,433.00	1,625,220,010.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,173,841,400.00	1,588,560,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,173,841,400.00	1,588,560,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,911,033.00	36,659,410.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	101,911,033.00	36,659,410.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,218,095,433.00	1,601,581,900.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,218,095,433.00	1,601,581,900.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,205,580,537.49	1,389,474,769.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	884,911,897.00	1,026,458,182.2
210101	Үндсэн цалин	637,737,516.00	613,948,464.45
210102	Нэмэгдэл	180,913,670.00	302,656,108.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,170,568.00	53,680,173.31
210104	Урамшуулал	29,090,143.00	56,173,436.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,037,172.86	133,108,997.24
210201	Тэтгэврийн даатгал	78,018,677.86	93,567,297.42
210202	Тэтгэмжийн даатгал	7,410,678.00	10,431,646.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,982,817.00	8,234,275.52
210204	Ажилгүйдлийн даатгал	3,169,023.00	1,855,799.27
210205	Эрүүл мэндийн даатгал	17,455,977.00	19,019,978.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,646,008.64	36,659,409.00
210301	Гэрэл, цахилгаан	15,577,807.47	10,523,763.30
210302	Түлш, халаалт	17,130,706.58	18,294,328.70
210303	Цэвэр, бохир ус	5,937,494.59	7,841,317.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,906,000.99	57,408,647.48
210401	Бичиг хэрэг	3,714,700.00	10,590,964.00
210402	Тээвэр, шатахуун	5,238,400.00	4,249,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,017,435.99	13,657,823.48
210404	Ном, хэвлэл	146,000.00	425,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,486,025.00	8,154,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,303,440.00	20,329,850.00
2105	Нормативт зардал		2,797,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,797,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,570,940.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,570,940.00	

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,455,528.00	45,052,922.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,641,498.00	43,297,392.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	186,030.00	186,030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,000.00	69,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,052,990.00	87,989,112.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,052,990.00	87,989,112.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,514,895.51	212,107,130.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,000,000.00	58,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		42,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	16,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,514,895.51	154,107,130.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,404,224.15	154,107,129.01
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	110,671.36	1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	57,657,000.00	47,568,110.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	57,657,000.00	47,568,110.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	57,657,000.00	47,568,110.00
2200	Дотоод эх үүсвэрээр	57,657,000.00	47,568,110.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	57,657,000.00	47,568,110.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(57,657,000.00)	(47,568,110.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Эхний үлдэгдэл			
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,615,220,300.00	1,458,383,470.99	156,836,829.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,615,220,300.00	1,458,383,470.99	156,836,829.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,557,084,400.00	1,400,383,470.99	156,700,929.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,130,667,800.00	1,026,458,182.27	104,209,617.73
210101	Үндсэн цалин	687,452,000.00	613,948,464.45	73,503,535.55
210102	Нэмэгдэл	320,097,800.00	302,656,108.36	17,441,691.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,334,600.00	53,680,173.31	1,654,426.69
210104	Урамшуулал	67,783,400.00	56,173,436.15	11,609,963.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,640,100.00	133,108,997.24	19,531,102.76
210201	Тэтгэврийн даатгал	106,613,400.00	93,567,297.42	13,046,102.58
210202	Тэтгэмжийн даатгал	11,506,700.00	10,431,646.46	1,075,053.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,205,300.00	8,234,275.52	971,024.48
210204	Ажилгүйдлийн даатгал	2,301,300.00	1,855,799.27	445,500.73
210205	Эрүүл мэндийн даатгал	23,013,400.00	19,019,978.57	3,993,421.43
2104	Хангамж, бараа материалын зардал	86,497,500.00	65,512,157.48	20,985,342.52
210401	Бичиг хэрэг	7,504,600.00	10,590,964.00	(3,086,364.00)
210402	Тээвэр, шатахуун	5,350,000.00	4,249,910.00	1,100,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,377,500.00	13,657,823.48	16,719,676.52
210404	Ном, хэвлэл	15,662,300.00	8,529,110.00	7,133,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,145,000.00	8,154,500.00	4,990,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,458,100.00	20,329,850.00	(5,871,750.00)
2105	Нормативт зардал	5,200,000.00	2,797,500.00	2,402,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,200,000.00	2,797,500.00	2,402,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,417,300.00	33,414,600.00	2,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00	0.00
210602	Тавилга	17,417,300.00	17,414,600.00	2,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,254,400.00	51,102,922.00	8,151,478.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,500,000.00	49,347,392.00	7,152,608.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,166,600.00	1,500,000.00	666,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	433,400.00	186,030.00	247,370.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,000.00	69,500.00	41,500.00

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	43,400.00	0.00	43,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,407,300.00	87,989,112.00	1,418,188.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	89,407,300.00	87,989,112.00	1,418,188.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,135,900.00	58,000,000.00	135,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,135,900.00	58,000,000.00	135,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,135,900.00	42,000,000.00	135,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,000,000.00	16,000,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,615,220,300.00	1,458,383,470.99	156,836,829.01
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,588,560,600.00	1,434,453,470.99	154,107,129.01
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,588,560,600.00	1,434,453,470.99	154,107,129.01
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	26,659,700.00	23,930,000.00	2,729,700.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,659,700.00	23,930,000.00	2,729,700.00
	Тохируулгын дүн			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
	Ажиллагсдын тоо	41	41	
	Удирдах ажилтан	1	1	
	Гүйцэтгэх ажилтан	31	31	
	Үйлчлэх ажилтан	9	9	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

<i>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон</i>		<i>/төгрөгөөр/</i>
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		36,659,410.00
УРСГАЛ ЗАРДАЛ		36,659,410.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,659,409.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		36,659,409.00
Гэрэл, цахилгаан		10,523,763.30
Түлш, халаалт		18,294,328.70
Цэвэр, бохир ус		7,841,317.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		36,659,410.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		36,659,410.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		36,659,410.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөрөнгө данснаас хасахгүй байх, төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Дэлгэрмаа, аудитор М.Батмагнай, аудиторын туслах Э.Ундрах-Эрдэнэ, С.Номин, Б.Болорчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Олон улсын хөтөлбөрийн сургалттай "Монгол тэмүүлэл" ахлах сургууль нь 2011 онд үүсгэн байгуулагдаж 10 дахь жилдээ сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байгаа БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус сургуулийн зорилго нь чанартай боловсрол олгож, дэлхийд өрсөлдөхүйц чадвартай Монгол иргэнийг бэлтгэх зорилгын хүрээнд 13 үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Ковид-19 цар тахлын улмаас санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүйг тайлангийн хугацаанд залруулан авсан.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,380,720.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,807.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж материаллаг байдлын суурь үзүүлэлт болох нийт зардал өмнөх оноос өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,918,119.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,181.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 173,137.5 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	562.5	397.7	(164.8)
Бараа материал	154,198.9	47,847.0	(106,351.9)
Үндсэн хөрөнгө	3,957,491.9	3,890,871.1	(66,620.8)
Нийт хөрөнгө	4,112,253.3	3,939,115.8	(173,137.5)
Өр төлбөр		33.4	33.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	265,942.6	265,942.6	0
Хуримтлагдсан үр дүн	3,846,310.2	3,673,139.8	(173,170.9)
Нийт өр төлбөр ба цэвэр өмч	4,112,253.3	3,939,115.8	(173,137.5)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 47,847.0 мянган төгрөг болж 106,351.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу ашиглалтад тавьж олгосон хангамжийн материалыг данснаас хасч бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны 364 дүгээр тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 58 нэр төрлийн 184,301.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж 85,287.6 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1349 дугаар албан бичгээр 65,043.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан;
- Төсвийн хөрөнгөөр 47,568.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, сурагчдын 5,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан зэргээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,890,871.1 мянган төгрөг болж 66,620.8 мянган төгрөгөөр буурсан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өөрийн орлого өмнөх оноос 391,891.5 мянган төгрөгөөр буюу 28.9 хувиар өссөн нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон;
- Урсгал зардал өмнөх оноос 530,658.1 мянган төгрөгөөр буюу 38.6 хувиар өссөн нь ажилласан жилийн нэмэгдэл өссөн, дутуу орон тоонд ажилтан шинээр авч ажиллуулсантай холбоотой цалин хөлсний зардал өссөн мөн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал өссөнтэй тус тус холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,910,673.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,910,673.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин хөлстэй холбоотой зардлыг 105,393.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 67,465.9 мянган төгрөг зэргээр нийт 237,827.1 мянган төгрөгөөр бууруулж 1,672,846.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслийг бууруулж баталсан нь төсвийг хэмнэлттэй зарцуулахтай холбоотой байна.

Тайлант онд сургуулийн шинэ байранд нүүж орохоор тооцоод, байр ашиглалттай холбоотой зардлыг төлөвлөгөөнд тусгасан боловч цар тахалтай холбоотойгоор сургуулийн барилгын явц удааширсан тул төсвийн тодотголоор батлагдсан төсвийг байр ашиглалттай холбоотой зардал 57,626.5 мянган төгрөгөөр бууруулан 1,615,220.3 мянган төгрөг болгон тодотгол хийсэн.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,588,560.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 26,659.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос нийт 1,615,220.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,588,560.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 23,930.0 мянган төгрөг нийт 1,612,490.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,458,383.5 мянган төгрөгийг зарцуулж 154,107.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,458,383.5 мянган төгрөг буюу 90.3 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг 123,740.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 20,985.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний

төлбөр, хураамж зардлыг 8,151.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 156,700.9 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 135.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71802	Ерөнхий боловсрол	1,615,220.3	1,458,383.5	156,836.8	90.3
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,557,084.4	1,400,383.5	156,700.9	89.9
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	58,135.9	58,000.0	135.9	99.8

/мянган төгрөг/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгыг Ерөнхий боловсролын 133 дугаар сургуульд түр ашиглуулж байгаатай холбоотойгоор ашиглалтын зардлыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн 36,659.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 36,659.4 мянган төгрөгийг зарцуулсан. Тус нэмэлт санхүүжилтийн орлого нь Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд боловсрол ШУ-ны салбарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлтийн хувь 95.0 хувьтай байна. Хүрэх үр дүнд бүрэн хүрч ажиллаагүй нь цар тахалтай холбоотойгоор гадаадын их дээд сургуульд элсэн орогчдын тоо буурсан, засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр олгогдоогүйтэй холбоотой байна.

Тайлант онд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх тус хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон хөрөнгийн зардалд нийт 1,615,220.3 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,458,383.5 мянган төгрөг төгрөгийг зарцуулж 90.3 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 4.7 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

Сангийн яамнаас батлагдсан төсвийг тус байгууллагад албан бичиг, шийдвэр хавсарган ирүүлдэггүй, төсвийн төсөлтэй холбоотой тайлбар тодруулга авахгүй төсвийг үндэслэлгүй хасч төрийн сангийн системд оруулж байна. Мөн тодотгосон төсвийг албан бичгээр хүргүүлдэггүй, ямар шалтгаанаар тодотгол хийсэн нь тодорхойгүй зэрэг хяналт тавихад хүндрэлтэй байгааг цаашид анхаарах шаардлагатай.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах

ерөнхий чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд дараах асуудлууд анхаарал татсан болно. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын дагуу анх батлагдсан төсвийг 10 хувиар хэмнэж ажилласан боловч тус тогтоол гарснаас хойшхи хугацаанд 17,414.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч төсвийг хэмнэлтгүй зарцуулсан;
- Элсэлтийн шалгалт авахтай холбоотойгоор шалгалтын материал засах төхөөрөмжийн түрээсийн төлбөрт 4,000.0 мянган төгрөгийг "Тэмүүлэл багшийн хөгжил" төрийн бус байгууллагад шилжүүлсэн;
- Худалдаа үйлдвэрлэлийн их сургуультай 2020/57 тоот "Ашиглалтын гэрээ" байгуулан хичээлийн байрыг түрээсээр ашиглаж, тайлант онд хамаарах түрээсийн зардлыг БШУЯ хариуцан төлж байгаа тул тус сургуулийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 3,456,901.3 мянган төгрөгийн барилга байгууламжийг 2020 оноос хойш өөрийн үйл ажиллагаанд ашиглаагүй ЕБ-ын 133 дугаар сургуульд "Түр ашиглуулах гэрээ"-ний дагуу ашиглуулж байгаа боловч өөрийн үйл ажиллагааг түрээсийн байранд явуулж сургалтын орчин бүрдүүлэлт хангалтгүй багш, сурагчдад хүндрэлтэй байна. Мөн тус барилгыг шилжүүлээгүйгээс элэгдлийн зардал тус сургуулийн санхүүгийн тайланд бүртгэгдэж байгаа зэрэг асуудлуудыг анхаарч авч үзэх шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль нь нийт 1,924,458.4 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5,864.2 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй, 19,789.2 мянган төгрөгийн мэдээллийн холбогдох шийдвэрийг байршуулаагүй зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 54,246.4 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илрүүлснээс 52,879.2 мянган төгрөгийн 8 алдааг залруулж, зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 1,367.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 51,650.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагын биелэлт 71.4 хувь, 34,490.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 97.5 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	51,650.1	2	51,650.1	2	-	50.0
Зөвлөмж	3	34,490.0	3	34,490.0			97.5
Нийт дүн	7	86,140.1	5	86,140.1	2		71.4

Шилэн дансны мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах болон газар эзэмших эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах талаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг 2020 онд тус сургуулийн нэр дээр шилжүүлэн өгсөн боловч Нийслэлийн боловсролын газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй, шилжүүлэн авах хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль болон Ерөнхий боловсролын 133 дугаар сургууль хоорондын эвлэрлийн гэрээний дагуу тус сургуулийн санхүүгийн тайланд бүртгэлтэй барилгыг 133 дугаар сургууль ашиглаж байгаа боловч тус гэрээний хүчинтэй хугацаа дууссан байгаа тул гэрээг сунгах эсэх болон хэрхэн шийдвэрлэгдэх нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 246,711.2 мянган төгрөгийн 16 алдаа зөрчил илэрснээс, 227,640.5 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 288.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17,414.6 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,367.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 7 алдаа, зөрчлийн дүн 19,070.7 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 19,181.2 мянган төгрөгөөс хэтрээгүй тул “Зөрчилгүй дүгнэлт” өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 10 алдаатай холбоотой 227,640.5 мянган төгрөгийн алдааг залруулж дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөөг 58,135.9 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардлын төлөвлөгөөг 7,000.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Шалгалтын хураамжийн орлогыг 110.0 мянган төгрөгөөр дутуу хураан авсан;
- Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дүнг 50,188.9 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Хөрөнгийн ашиглалтын хугацааг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан хугацаанаас зөрүүтэй тооцсон болон санхүүгийн програмын тооцооллын алдаанаас шалтгаалж элэгдлийн зардлыг 7,066.4 мянган төгрөгөөр илүү, 6,263.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэх 6,050.0 мянган төгрөгийн хөрөнгийг зардлаар тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай 5,486.8 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын шийдвэрээр үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосныг бүртгэлд тусгахдаа 590.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
- Санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдэл нь дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлээс 2,645.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Нийгмийн даатгалын тайланд 399.4 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнасан, гэрээт ажилтны цалингаас суутгах ХХОАТ-ыг 119.8 мянган төгрөгөөр дутуу суутгаснаас ажилтанд цалинг илүү олгосон;
- Өөр байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 83,584.1 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг балансаас балансад шилжүүлэн бүртгэх эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр бүртгэлд тусгасан зэрэг асуудлыг тус тус аудитаар залруулав.

4.2 Төлбөрийн акт

Үндсэн цалингийн албан тушаалын зэрэглэлийг буруу тогтоосноос 1 ажилтанд 288.8 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”-ийг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг буруутай этгээдээр төлүүлэх, Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн 17,414.6 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тус сургуулийн 000012659 гэрчилгээний дугаартай 3782 м² газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр

тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8-д "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газар эзэмших эрхийн гэрчилгээг үнэлж бүртгэлд тусгах, Албан шаардлага хүргүүлэх

2. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол гарснаас хойшхи хугацаанд 17,414.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч төсвийг хэмнэлтгүй зарцуулсан нь тус тогтоолын 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах, засгийн газрын тогтоолоор хориглосон худалдан авалтыг хийхгүй байх, Албан шаардлага хүргүүлэх

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэл, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга", 54.5.5 "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэн гаргах, Албан шаардлага хүргүүлэх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Сурагчдад үйлчилгээ үзүүлдэг цайны газрын үйл ажиллагаа түр зогссонтой холбоотойгоор 1,144.7 мянган төгрөгийн үлдэгдэл хүнсний материалыг ажилтнуудад үнэ төлбөргүй тараан олгож төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ" 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүнсний материалыг цайны газрын үйл ажиллагаанд зарцуулах, зориулалтын бусаар ашиглахгүй байж, хадгалалт, хамгаалалт, хяналтыг сайжруулж, бараа материалын зарцуулалт хийж буй ажилтнууд хариуцлагатай ажиллах, төсвийг хэмнэлттэй зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2. **Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

ТӨБЗГ-т актлах санал хүргүүлэхдээ хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дүнг алдаатай хүргүүлснээс тогтоолд тусгагдсан дүнгээс 222.6 мянган төгрөгөөр илүү дүнгээр хөрөнгийг данснаас хассан.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 6 дугаар зүйлийн 6.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт хагас жилд 1 удаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-т хөрөнгө актлах саналаа хүргүүлэхдээ хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дүнг нягтлан шалгаж, хөрөнгө актлах зөвшөөрөлд тусгагдсан дүнгээс зөрүүгүй байдлаар бүртгэлд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
					тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөөг 58,135.9 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардлын төлөвлөгөөг 7,000.0 мянган төгрөгөөр дутуу;	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөө болон урсгал зардалд залруулга хийсэн	1	65,135.9	1	65,135.9								
2	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Шалгалтын хураамжийн орлогыг 110.0 мянган төгрөгөөр дутуу хураан авсан;	Орлогыг нөхөн хураан бүрдүүлсэн	1	110.0	1	110.0								
3	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дүнг 50,188.9 мянган төгрөгөөр илүү;	Үндсэн хөрөнгийн дүнг залруулсан	1	50,188.9	1	50,188.9								
4	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Хөрөнгийн ашиглалтын хугацааг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасан хугацаанаас зөрүүтэй тооцсон болон санхүүгийн програмын тооцооллын алдаанаас шалтгаалж элэгдлийн зардлыг 7,066.4 мянган төгрөгөөр илүү, 6,263.7 мянган төгрөгөөр дутуу;	Үндсэн хөрөнгийн элэгдлийг залруулсан	1	13,330.1	1	13,330.1								
5	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэх 6,050.0 мянган төгрөгийн хөрөнгийг зардлаар бүртгэсэн;	Хөрөнгөөр хүлээн зөвшөөрч залруулсан	1	6,050.0	1	6,050.0								
6	Ерөнхий боловсролын Монгол	АХГ-2022/40/НА-	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 5,486.8 мянган төгрөгийн хөрөнгийг бараа	Хөрөнгөөр хүлээн зөвшөөрч залруулсан	1	5,486.8	1	5,486.8								

	тэмүүлэл сургууль	СТА-ТШЗ	материалын дансанд бүртгэсэн;																
7	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	ТӨБЗГ-ын шийдвэрээр үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосныг бүртгэлд тусгахдаа 590.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан;	Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг залруулсан	1	590.0	1	590.0											
8	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайланд тусгагдсан бараа материалын үлдэгдэл нь дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлээс 2,645.5 мянган төгрөгөөр дутуу;	Санхүүгийн байдлын тайланд бараа материалыг залруулсан	1	2,645.5	1	2,645.5											
9	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Нийгмийн даатгалын тайланд 399.4 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнасан, гэрээт ажилтны цалингаас суутгах ХХОАТ-ыг 119.8 мянган төгрөгөөр дутуу суутгаснаас ажилтанд цалинг илүү олгосон;	Татвар, нийгмийн даатгалын тайланд залруулга хийсэн	1	519.2	1	519.2											
10	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Өөр байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 83,584.1 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг балансаас балансад шилжүүлэн бүртгэх эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр бүртгэлд тусгасан зэрэг асуудлыг тус тус аудитаар залруулав.	Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг бууруулж залруулсан	1	83,584.1	1	83,584.1											
11	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	ТӨБЗГ-т актлах санал хүргүүлэхдээ хөрөнгийн тоо хэмжээ үнийн дүнг алдаатай хүргүүлснээс шалтгаалж тогтоолд тусгагдсан дүнгээс 222.6 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.	ТӨБЗГ-т хөрөнгө актлах саналаа хүргүүлэхдээ хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дүнг нягтлан шалгаж, хөрөнгө актлах зөвшөөрөлд тусгагдсан дүнгээс зөрүүгүй байдлаар бүртгэлд тусгах	1	222.6												1	222.6
12	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Тус сургуулийн нэр дээр 2020 онд гэрчилгээ нь олгогдсон 000012659 дугаартай 3782 м2 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Газар эзэмших эрхийн гэрчилгээг үнэлж бүртгэлд тусгах	1														

13	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Цайны газрын үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор 1,144.7 мянган төгрөгийн үлдэгдэл хүнсний материалыг ажилтнуудад үнэ төлбөргүй тараан олгосон байна.	Хүнсний материалыг цайны газрын үйл ажиллагаанд зарцуулах, зориулалтын бусаар ашиглахгүй байж, хадгалалт, хамгаалалт, хяналтыг сайжруулж, төсвийг хэмнэлттэй зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	1,144.7									1	1,144.7
14	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол гарснаас хойшхи хугацаанд тавилга эд хогшил худалдан авахгүй байх шийдвэр гарсан боловч 17,414.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна.	Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах, засгийн газрын тогтоолоор хориглосон худалдан авалтыг хийхгүй байх	1	17,414.6					1	17,414.6				
15	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Үндсэн цалин тооцох албан тушаалын зэрэглэлийг буруу тогтоосноос 1 ажилтанд 288.4 мянган төгрөгийн цалинг илүү олгосон	Илүү олгосон цалинг буруутай этгээдээр төлүүлэх	1	288.8					1	288.8				
16	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй.	Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн, үнэн зөв бэлтгэн гаргах	1							1				
Дүн					16	246,711.2	10	227,640.5	1	288.8	3	17,414.6			2	1,367.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
17	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль	АХГ-2022/40/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд 1 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 5,864.2 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, 19,789.2	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан	1	25,653.4						1	25,653.4	1	25,653.4	

			мянган төгрөгийн 3 удаагийн гүйлгээнд холбогдох шийдвэрийг байршуулаагүй.	гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох												
Дүн					1	25,653.4	-	-	-	-	1	25,653.4	1	25,653.4	-	-
Нийт дүн					17	272,364.6	10	227,640.5	1	288.8	4	43,068.0	1	25,653.4	2	1,367.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 07/А0150058
АХГ-2022/40/НА-СТА-ТМЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн цалингийн албан тушаалын зэрэглэлийг буруу тогтоосноос 1 ажилтанд 288,800.00 /хоёр зуун наян найман мянга найман зуу/ төгрөгийн цалинг илүү олгосон.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл"-ийг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 1 ажилтанд илүү олгосон 288,0000.00 /хоёр зуун наян найман мянга төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөр, нягтлан бодогч Х.Орхончимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Т.ОДОНЧИМЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Газар-17.Docx

001090067



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 25/2022/0058
АХГ-2000/40/НА-СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 5,864,174.00 /таван сая найман зуун жаран дөрвөн мянга нэг зуун далан дөрөв төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй, 19,789,200.00 /арван есөн сая долоон зуун наян есөн мянга хоёр зуу/ төгрөгийн ажил, гүйлгээний мэдээллийн холбогдох шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, иж бүрэн мэдээлэх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нягтлан бодогч Х.Орхончимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөрт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 32/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2020/40/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн нэр дээр бүртгэлтэй 000012659 гэрчилгээний дугаартай 3782 м2 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8 "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөр, нягтлан бодогч Х.Орхончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Т.ОДОНЧИМЭГ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-72.Docx

901080239



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 33/20150058

Улаанбаатар хот

АХГ-0026/40/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 17,414,600.00 /арван долоон сая дөрвөн зуун арван дөрвөн мянга зургаан зуу/ төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч төсвийг хэмнэлтгүй зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөр, нягтлан бодогч Х.Орхончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210

10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-73.Docx

001000243



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 26/А0150058
АХГ-2020/46/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэл, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" 54.5.4 "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга", 54.5.5 "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд, иж бүрэн бэлтгэн толилуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөр, нягтлан бодогч Х.Орхончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Т.ОДОНЧИМЭГ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-39.Docx

001081652

